

ТОЙМ



ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2024.10.07

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Тесла компанийн 3-р улирлын борлуулалт хүлээлтээс бага гарч хувьцааны ханш 3.0%-иар уналаа.
- NVIDIA компанийн гүйцэтгэх захирал Jensen Huang-ийн хэлснээр Blackwell бүтээгдэхүүний эрэлт маш өндөр байна.
- Хятадын Ардын Банк (PBoC) 800 тэрбум юань буюу 114 тэрбум ам.доллараар хөрөнгийн захаа дэмжих шийдвэр гаргалаа.
- Nomura банкны эдийн засагчид Хятадын зах зээлд 2015 оныхтой ижил уналт гарч болзошгүйг анхаарууллаа.
- Хятадын ТОП-100 үл хөдлөхийн компаниудын орлого 37.7%-иар уналаа.

2024 он 10-р сарын 7

Dow Jones	42,352.75
S&P 500	5,751.07
Nasdaq	18,137.85
DAX	19,120.93
FTSE 100	8,280.63
S&P/ASX 200	8,192.40
HANG SENG	23,006.50

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.8%	0.1%	5.0%	12.4%	26.8%	21.9%
S&P 500	0.9%	-0.2%	6.3%	20.6%	33.5%	31.0%
Nasdaq	1.2%	-0.3%	8.7%	20.8%	35.0%	24.4%

2024 оны 10 сарын 7-ны 12:00

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.6%	-1.1%	4.5%	14.1%	25.6%	25.7%
FTSE 100	0.0%	0.5%	1.2%	7.1%	10.5%	16.7%

2024 оны 10 сарын 7-ны 12:00

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.4%	0.6%	0.9%	9.1%	13.7%	-4.7%
Hang Seng	1.0%	8.7%	31.7%	34.8%	31.4%	-7.5%

2024 оны 10 сарын 7-ны 12:00

ЗӨВЛӨМЖ

Хятадын зах зээл:

Одоогоор техникийн хувьд эсэргүүцлийн бүсээ дээш эвдсэн.

Засгийн дэмжих бодлого нь жижиг хөрөнгө оруулагчдын ихээр татаж байна.

Зарим хөрөнгө оруулалтын банкнууд сэрэмжтэй байгааг анхаарах нь зүйтэй.

Геополитик болоод гадаад худалдааны эрсдэл хэвээр байна.



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

АНУ-ын ажил эрхлэлтийн тайлан сайн гарч зах зээл дахин өслөө.

Өнгөрсөн долоо хоногт Ойрхи Дорнодын мөргөлдөөн үргэлжилж АНУ-ын индексүүд уналттай байсан. Харин өнгөрөгч баасан гарагт АНУ-ын ажил эрхлэлтийн тайлан сайн гарч, хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлсэн. АНУ-ын зах зээл сүүлийн 4 долоо хоног тасралтгүй өслөө.

Ойрхи Дорнодын хурцадмал байдал эрчим хүчний бүтээгдэхүүний үнийг өсгөлөө.

Ойрхи Дорнодод өргөн хүрээтэй дайн дэгдэх төлөвтэй байгаа нь нефтийн үнэ сүүлийн сар орчмын хугацааны хамгийн өндөр түвшинд хүрч, эрчим хүчний хувьцаанд ашигтайгаар нөлөөлсөн ба эсрэгээрээ аялалын бизнес болон дэлхийн даяар бараагаа тээвэрлэдэг Nike гэх мэт үйлдвэрлэгч нарын хувьцаанд сөргөөр нөлөөлж байна.

Ажил байрны сайн мэдээ нь дайны сөрөг хандлагыг дарлаа.

Баасан гарагийн өглөө АНУ-ын ажил эрхлэлтийн тайлан зарлагдаж зах зээлийн сөрөг хандлагыг өөрчилсөн. 9-р сард ажил олгогчид 254,000 ажлын байр нэмсэн нь тооцооллоос бараг хоёр дахин их буюу 3-р сараас хойших хамгийн их ажлын байр бий болгосон үзүүлэлт хэмээн Хөдөлмөрийн яам мэдэгдэв. Мөн ажилгүйдлийн түвшин 4.1% хүртэл буурчээ.

Мөн ажлын байрны сайн тайлан нь урт хугацааны бондын өгөөжийг өсгөхөд хүргэсэн бөгөөд АНУ-ын 10 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж наймдугаар сарын 8-наас хойш өдрийн хамгийн дээд түвшинд (3.98%) хүрэв.

График 1: АНУ-ын Nasdaq индексийн ханшийн таамаглал





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын хувьцаануудын өсөлт эрчимжлээ

Хятадын хувьцааны үнэ богино хугацаанд эрс өссөн байна. Бээжингийн өргөн хүрээний дэмжлэгийн арга хэмжээнүүдийн нөлөөгөөр зах зээлд эерэг хандлага бий болжээ. Шанхайн Composite индекс 8.06%, CSI 300 индекс 8.48%-аар өссөн бол Хонконгийн Hang Seng индекс 10.2%-аар өсжээ. Хятадын үндсэн зах зээлүүд Үндэсний баярын өдөрт зориулан мягмар гарагт амралттай байлаа.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа уналттай байна

Хятадын үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаа тав дахь сардаа дараалан агшсан хэвээр байна. Албан ёсны үйлдвэрлэлийн PMI индекс есдүгээр сард 49.8 болж өссөн ч 50-аас доош түвшинд байгаа нь эдийн засгийн агшилтыг харуулж байна. Үйлдвэрлэлийн бус PMI индекс 50 болж, 21 сарын доод түвшинд хүрсэн нь барилга болон үйлчилгээний салбарын сул байдлыг илтгэж байна.

Caixin-ийн хувийн судалгааны үр дүн тааруу гарлаа

Хувийн Caixin/S&P Global-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны индекс есдүгээр сард 49.3 болж, өмнөх сарын 50.4-өөс доошилсон нь 2023 оны долдугаар сараас хойшхи хамгийн бага түвшин байв. Мөн үйлчилгээний PMI индекс 50.3 болж буурсан ч өсөлтийн бүсэд хэвээр байна. Энэ нь Хятадын эдийн засгийн сэргэх үйл явц удаашралтай байгааг харуулж байна.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлын борлуулалт 37.7% буурлаа

Хятадын шилдэг 100 хөгжүүлэгчдийн шинэ орон сууцны борлуулалтын үнэ жилийн өмнөхөөс 37.7%-аар буурч, наймдугаар сарын 26.8%-ийн уналтаас улам хурдсаж байна. Гэвч зах зээлийн хандлага сайжирсан бөгөөд Хятадын гурван том хот хязгаарлалтгүйгээр орон сууц худалдан авах боломжийг нээжээ. Гуанжоу хот энэ алхмыг анхлан хэрэгжүүлсэн бол Шанхай болон Шэньжэнь хотуудын хувьд орон сууцны урьдчилгаа төлбөрийн хэмжээ бууруулсан байна.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал

abillguan published on TradingView.com, Sep 29, 2024 22:40 UTC-4

Hang Seng Index Futures, 1W, HKEX: @20,924 |21,399 |20,616 |21,019 +99 (+0.47%)



ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
September 30, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
CCL CARNIVAL CORPORATION & PLC		PAYX PAYCHEX	NKE NIKE	RPM RPM	LEVI Levi's	STZ Constellation Brands		APOG apogee enterprises inc.	
		MC McCormick & Co.	LW Lamb Weston	CAG ConAgra Foods		ANGO angiodynamics			
		AYI Acuity Brands	RGP RGP						
		UNFI UNITED NATURE FOOD. BETTER FUTURE.							
http://eps.sh/cal								© 2024 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
October 07, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
NAPA DUCKHORN INDUSTRIES		PEP PEPSICO	SABR SARATOGA INVESTMENT CORP.	HELE Helen of Troy	AZZ AZZ	TLRY TILRAY	AHR AHER	JPM JPMORGAN CHASE & CO.	
		ACCD Accolade		BYRN byrna	APLD APPLIED BLOCKCHAIN	DAL DELTA		WFC WELLS FARGO	
					BSET Bassett	DPZ DPZ		BLK BlackRock	
					ETWO E2OPEN	THRX THERA technologies		BNY BNY	
					REEL Richardson Electronics	NEOG NEOGEN		FAST FASTENAL	
http://eps.sh/cal								© 2024 Earnings Whispers	